

**“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04-р сарын 22-ны өдөр

Дугаар:22/01

Улаанбаатар хот.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн хурлын зааланд 2022.04.22-ны өдрийн 16.00 цагт эхлэв.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын гишүүн Ж.Олонбаяр хурлын ирцийг бүртгэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн талаарх мэдээллийг гаргаж, хурлын тооллогын комиссын дарга О.Шинэхүүг танилцуулахыг урилаа.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга О.Шинэхүүгийн танилцуулснаар:

Хуралд саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас саналын эрхтэй 126,701.0 ширхэг хувьцаа эзэмшдэг 9 хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь 94 % болж, Компанийн тухай хуулийн 69.1-д “Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг бүрэн хангаж байна.

Хуралд Б.Энхжаргал, Д.Дашдорж, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэчимэг, Ц.Эрдэнэсүх, Б.Мөнхбат, Г.Алтансүх, С.Пүрэвжав, С.Мягмарсүрэн нарын 9 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хувьцаа эзэмшигч Б.Батсайхан /ОЛ67082377/ хурлын ирц бүртгэж, мэдээлэгдсэнээс хойш ирсэн тул хурлын дэгийн дагуу ирцэд бүртгэхгүйгээр хуралд оролцуулав.

Хурал даргалагч Б.Мөнхбат ээлжит хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэгийг танилцуулсны дараа хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурлын дэг:

1. Хэлэлцэх асуудлын талаарх ТУЗ-ийн мэдээлэл, дүгнэлтийг танилцуулах /20 мин/
2. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсан асуулт, хариулт. /хүн бүр 5 мин/
3. Тоологын комисс санал өгөх журмыг танилцуулж, саналын хуудсаар санал авах
4. Санал хураалтын дүнг шийдвэр бүрээр гаргаж хуралд танилцуулна. /10 мин/
5. Санал хураалтын дүнг үндэслэн хурлаас гарах шийдвэрийг танилцуулах /5 мин/
6. Хурлыг хаах

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд:

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө, 2022 оны удирдлагын зардлыг батлах
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд гүйцэтгэх захирал Э.Тэмүүжинг сонгох

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хурлын дарга Б.Мөнхбат уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасан шаардлагын дагуу хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Үндэсний шуудан /, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 15 хоногийн давтамжтайгаар 2 удаа тус тус зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Компанийн 2021 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Компанийн тайлан, бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлын тооцоотой та бүхэн компани дээр ирж урьд нь танилцсан, одоо ч та бүхэнд хэвлэж тараасан байгаа. Та бүхний санал бодлыг сонсьё.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигч Д.Дашдорж: Үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Асуух юм байна. Өнгөрсөн онд барилга угсралтын ажил гүйцэтгээд авч чадаагүй 4 тэрбум 798 сая төгрөг байна гэсэн. Өнгөрсөн онд ажлаа гүйцэтгээд авч чадаагүй энэнээс өөр хэдэн төгрөг байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд гүйцэтгэсэн Сэлбэ дэд төвийн 28мВт чадалтай дулааны станцын барилга угсралтын ажлын санхүүжилтын 55,5% нь Азийн хөгжлийн банк, 44,5% нь Нийслэлийн засаг даргын тамгын газраас санхүүждэг юм. Азийн хөгжлийн банкны санхүүжилт хийгдсэн. НЗДТГазраас 3 тэрбум төгрөг санхүүжээгүй байгаа.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Баянзүрх дүүргийн 88 айлын орон сууцыг 2020 онд улсын комисст хүлээлгэн өгсөн юм байна. Одоо болтол орон сууцаа борлуулж дуусаагүй юм уу?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Орон сууцны борлуулалт хийгдэж байгаа. Орон сууцны үнэ өсч байгаа учраас үнийн өсөлтийг харгалзан, үнэ хүргэх байдлаар хүлээзнэж байгаа.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Ипотекийн зээл зогсвол яах билээ? Эрсдэлээ тооцож үзсэн юм уу.

Хувьцаа эзэмшигч Б.Энхжаргал: Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин буруу хариулт өглөө. 2021 онд орон сууцны 4,0 тэрбум төгрөг борлуулалтанд тооцогдсон байгаа. Орон сууцаа 2020 оны 12-р сард улсын комисст хүлээлгэн өгсөн. 2021 онд борлуулалт хийгдсэн. Нийт 88 айлын орон сууц, 5 аж ахуйн нэгжтэй юм. Өнөөдрийн байдлаар 14 байр борлогдоогүй байна. Орон сууцны санхүүжилт тухай бүр борлуулалтанд тооцогдож яваа. Бид орон сууц борлуулахдаа 100% санхүүжилт авч байж түлхүүр гардуулах зорилготой байгаа.

2021 онд олсон ашиг бол Сэлбэ дэд төвийн 28мВт чадалтай дулааны станц, Баянзүрх 88 айлын орон сууцнаас олсон ашиг юм.

2021он ажил эрхлэхэд хүндрэлтэй жил байлаа. Засгийн газрын шийдвэрээр ажил зогсож, хөл хорионд орсон.

Тээвэр зуучийн хүндрэлтэй асуудлаас болж түрээсийн 316м² талбай түрээслээд худалдаа эрхэлдэг байсан Сэкуд ХХК-ийн үйл ажиллагаа доголдож, түрээсийн байраа буцаан өгснийг бид спорт зал болгохоор барилга засварын ажил эхлүүлж байна. Энэ талбайг түрээслээд жилд 36 сая төгрөгийн ашиг олдог байсан бол спорт зал болгочихвол жилд 100 сая, зардлаа хасахад 70,0 сая төгрөг олохоор байгаа тул спорт зал болгох ажлыг дэмжиж байна.

Жижиг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа доголдсоноос түрээсийн байраа буцааж өгөх асуудал нэлээд гарч байгаа тул байрны ашиглалтыг сайжруулах талаарх төлөвлөгөө, шийдвэрээ ТУЗ-д танилцуулж, шуурхай ажиллах шаардлагатай байна.Сайн ажиллаарай гэж захъя. Хэдэн зөвлөгөө өгье:

-2021 онд 4 тэрбумын ашигтай ажилласан бол 2022 онд 8 тэрбум болгохын төлөө ажиллах хэрэгтэй.

-Барилгын материалын үнэ нэмэгдсэн учир одоогоор тендерт оролцоогүй байгаа. 2023 онд хийх ажлаа олж авахын тулд тендерт оролцох тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй. Зах зээл дээр судалгаа хийх

-Манай компани 80 жилийн түүхтэй. Би сүүлийн 30 жил захирал, 10 жил ерөнхий инженер хийсэн.Ажилласан байдлаа дүгнэхэд 30 жил субботник хийсэн байх юм. Сүүлийн 2-3 жил орон сууц барьснаар ашигтай ажиллаж ирлээ.

-Материалын худалдаа эрхэлж, ашиг олох талдаа анхаарч ажиллах

-Бетон эдлэл, Төмөр хийцийн үйлдвэрийг бие даалгах, өргөжүүлэх. материал үйлдвэрлэл дээр гүйцэтгэх удирдлага анхаарч ажиллах. Материал үйлдвэрлэл маань барилга угсралтын ажлаа бодвол эрэлт ихтэй, тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжтой юм.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Орон сууц барих ашиг сайтай байна уу?

Хувьцаа эзэмшигч Б.Энхжаргал: Контор байрлаж байгаа энэ талбай дээр орон сууц барихаар төлөвлөж байгаа. Хотын төвд 6-аас дээш давхар барилга барихгүй гэсэн хотын даргын шийдвэр гарсан тул харзнаж байна. 6 давхар орон сууц баривал ашиг гарахгүй. 15 давхар орон сууц баривал ашигтай. Конторын газар дээр орон сууц барьж зарвал ашигтай. Хажуугийн нөхөд зургаа хийлгэсэн байгаа. Хотын даргын шийдвэрийг харзнаад энэ хавар эхлүүлэх байснаа түр хойшлуулсан байгаа.

“Хүрд орон сууц” контор 2021 онд 1,8 тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ эрхэлж, 20-30% ашигтай ажилласан. “Хүрд Нарлаг” зочид буудлын байрыг түрээсэлж 100,0 сая төгрөг олсон. Урьд нь 10 хүн ажиллаад жилд 10 сая төгрөгийн ашиг ч олдоггүй байсан тул түрээсэлсэн юм.

2022 онд Сэлбэ дэд төвийн дулааны станцын НӨАТ чөлөөлөлт тооцогдсон 4,798 тэрбум төгрөг, мөн үлдэгдэл 3,0 тэрбум төгрөгийн санхүүжилт, Баянзүрх орон сууцны үлдэгдэл санхүүжилт орно. 2022 оны эхний хагас жилд 660,0 сая төгрөгийн татвар төлнө.

Би 2021 оны 01-р сараас компанийн үйл ажиллагаанд өдөр тутам оролцохгүй байгаа. 2021 онд эрүүл мэндийн шалтгаанаар 10 сар Солонгос улсад эмчлүүлж байгаад ирсэн. Тиймээс гүйцэтгэх удирдлагын үүрэгт ажлаа 2021 оны 05-р сарын 14-нд Э.Тэмүүжинд албан ёсоор шилжүүлсэн байгаа.

2021 онд компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд биечлэн оролцож чадаагүй ч манай гүйцэтгэх удирдлага сайн ажилласан байна.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Өөрийн газар дээр орон сууц барих ашигтай гэж байна. Газраа орон сууц болгоход нэг л удаа ашиг олоод газаргүй болно биз дээ.

Хувьцаа эзэмшигч Б.Батсайхан : Танай компанийн хувьцаа хэт төвлөрөлттэй байна. Хувьцаагаа хуваах тал дээр ямар бодолтой байна?

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Тендерийн баталгааг чөлөөлөх тухай яригдаж эхлээд байна. Ингэвэл барилга угсралтын компаниудад ашигтай болох уу? “Нарлаг” зочид буудлын ашиглалтын байдлыг харгалзан үзээд контороосоо өмнө газар дээр нь орон сууц баривал яасан юм бэ? Хэдэн талаасаа хашигдаад барилга барих ч боломжгүй болчих юм биш биз?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: “Нарлаг” зочид буудлын эргэн тойронд цэцэрлэг, Зүүний үйлдвэр-Тагнуулын дээд сургууль, НАА-н ТМ Сургууль байгаа тул хашигдах асуудал байхгүй. Тендерийн баталгааг чөлөөлөгдвөл барилга угсралтын компаниудад ашигтай. Бид зарим тохиолдолд 3 жилээр ч мөнгөө банкинд тусгаарлуулж байна.

Хувьцаа эзэмшигч Б.Энхжаргал: Өмч хувьчлалаар Цахилгаан сантехник угсралтын нэгдсэн трестийн харьяа салбар нэгжүүд дагалдан ирсэн болохоор манай компани дүүрэг болгонд газартай. Зочид буудлын бизнес цэцэглэж байх үед “Нарлаг” зочид буудлын суурин дээр 13 давхар зочид буудал барихаар зураг хийлгэсэн ч бариагүй ээ.

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат: Б.Энхжаргалын хэлсэн 40 жил ашиггүй ажилласан гэдэгтэй санал нийлэхгүй байна. Бид жил бүр тодорхой хэмжээний ашиг хуримтлуулсаар өнөөдрийн түвшинд хүрсэн.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Би 2021 оны 01-р сараас гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэж байгаад 2021 оны 05-р сараас гүйцэтгэх захирлаар ажиллаж ирлээ. 2019-2021 онуудад цар тахлын нөхцөл байдал компанийн бүтээн байгуулалтанд хүндээр туссан. Манай компани дээр нэлээд олон удаа халдвар тархсан. Нийслэлийн хэмжээнд хөл хорио тогтоох, QR код олгохгүй байх, ажилтнууд ажилдаа ирж чадахгүй байх, гадаадаас захиалсан тоног төхөөрөмж хугацаандаа ирэхгүй байх, гэрээт ажил шахагдах зэрэг асуудлууд байлаа. Мөн гүйцэтгэх захирал ажлаа өгсөн, Материал худалдаа хангамжийн дарга ажлаа өгсөн хүнд үед энэ орон зайг манай ажилтнууд хагас бүтэн сайнгүй ажиллаж байж давж гарлаа. Өнөөдөр бид Сэлбэ дэд төвийн 28мВт дулааны станцаа улсын комисст хүлээлгэж өгөөд сууж байна. Сэлбэ дэд төвийн дулааны станц ашиглалтанд орсноор 110 уурын зуух буулгах, хотын утаа тодорхой хэмжээгээр багасах ач холбогдолтой юм.

Манай гүйцэтгэсэн Сэлбэ дэд төвийн 28мВт дулааны станцыг Солонгос улсын хөрөнгөөр 10 аймагт хэрэгжих дулааны станцын төслийн жишиг төсөл болгохоор нийслэлээс судалж байгаа. Мөн Увс аймгийн Хяргас суманд Хөв цөөрөм барьсан нь Байгаль орчны яамны жишиг төсөл болохоор яригдаж байгаа.

Цар тахлын улмаас барилгын материалын үнэ огцом нэмэгдсэнтэй холбоотойгоор одоогоор тендерт оролцоогүй, судалж байна.

Цаашид компанийн бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, цалин нэмэгдүүлэх, урамшуулал олгох, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хүний нөөцийг бүрдүүлэх, сэтгэлгүй ажилтны орон тоог цомхотгох бодлого барьж ажиллана.

Төлөөлөн удирдах зөвлөл, Захирлын зөвлөлийн хурал өнгөрсөн онд цөөн хуралдсан. Энэ онд үйл ажиллагааг тогтмолжуулна.

Хувьцаа эзэмшигч Д.Дашдорж: Би энэ компанид олон жил ажилласан. 1992 оноос 30 жил ногдол ашиг тарааж байна. Энэ 30 жилд би 10-20 сая төгрөг авсан байх. Энэ жил онцгой жил, өндөр ногдол ашиг тарааж байна. Иймд гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүдэд баяр хүргэмээр байна. Тэгэхдээ ийм бол тэр болгон тохиолдохгүй ээ. Энэ бол боломж. 2023 онд бидний ирээдүйг одооноос бодох хэрэгтэй. Үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх тал дээр анхаарч ажиллахыг дэмжиж байна.

2020, 2021, 2022 онуудад ИТА нарын цалин улсын дундажаас бага байна. Өнөөдөр зах зээл дээр ИТА нарын цалин хэд дахин өндөр байгаа гэдгийг бодолцох хэрэгтэй. Инфляцийн түвшинтэй уялдуулан цалинг нэмэгдүүлэх саналтай байна. Чадварлаг ИТА нар энэ цалингаар ажиллахгүй л болов уу?

ИТА нарт барилга угсралтын ажлын үр дүнгийн урамшуулал олгож байх. ТУЗ-ийн гишүүдийн нэрэмжит, олон жил захирал хийсэн Б.Энхжаргалын нэрэмжит шагнал гэж бий болгоод жил бүр олгодог байх хэрэгтэй.

Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна. Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах саналтай байна.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжингээс асууя. 2021 онд нийт хэдэн ажилтантай ажиллав? ИТА нарын дундаж цалин хэдэн төгрөг байв?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Компанийн хэмжээнд 2021 онд бетон эдлэлийн цех, төмөр хийцийн үйлдвэртэйгээ нийт 90 гаруй хүн ажиллалаа. Компанийн дундаж цалин 890,0 мянган төгрөг байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Батсайхан: Би 1990 оноос брокерийн пүүсэд ажиллаж байгаа. Монголын хөрөнгийн бирж дээр танай компанийн хувьцааны арилжаа явагдахгүй байгаа. Уг нь танай компани МХ Биржид нэр хүндтэй компани.Үйл ажиллагаагаа өргөтгөж байж цалингаа нэмэгдүүлэх хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Хувьцааны арилжаа явагддаггүй гээд хасагдах компанийн жагсаалтанд орсон байгаа. Хувьцаагаа хуваахгүй юм уу?. Зах зээл дээр танай компанийн хувьцааны ханш 4000 төгрөг байгаа. Бизнесийн үйл ажиллагааг томруулахын тулд хувьцааны арилжаа хийх, хувьцаагаа хуваах тал дээр ажиллах хүсэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлд хүсэлт гаргаж байна. Хувьцаагаа үнэ цэнэтэй болгомоор байна.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав. : Компанийн санхүүгийн тайлантай танилцмаар байна.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Компанийн 2021 оны санхүүгийн тайланг Монголын хөрөнгийн биржийн сайтад байршуулсан, “Өдрийн сонин”-д нийтлүүлсэн. Энэ ширээн дээр ч байна. Танилцахад татгалзах зүйлгүй.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Хувьцаагаа хуваах тал дээр анхаарч ажиллахыг Б.Энхжаргалд тухайлан хүсч байна.

Хувьцаа эзэмшигч Б.Энхжаргал: Хувьцаагаа хуваах гэдгийг би сайн ойлгохгүй байна. Нэмэлт хувьцаа гаргах юм уу?

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Хувьцаагаа хувааснаар зах зээл дээр хөрвөх чадвар нь сайжирна. Одоогоор компанийн хувьцаа 4000 төгрөг дээр гацсан байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат: Хувьцаагаа хуваах талаар яривал өнөөдрийн хурал дуусахгүй бололтой. Бид Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж байж шийдвэр гаргана. Одоо дараагийн асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр гүйцэтгэх захирал Э.Тэмүүжинг сонгох асуудлыг хэлэлцье.

Э.Тэмүүжингийн анкетыг танилцуулья. Э.Тэмүүжин 1988 онд Улаанбаатар хотод төрсөн. 2010 онд ШУТИС-ийг цахилгааны инженер мэргэжлээр төгссөн. 2011 онд АНУ, 2012 онд Канадад хэлний бэлтгэлд суралцсан. Англи хэлтэй. 2012-2021 он хүртэл компанид төслийн менежерээр ажиллаж байгаад 2021 оны 05-р сараас гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа. Э.Тэмүүжин 2021 онд ковидын үед компанийг удирдаж, Сэлбэ дэд төвийн дулааны станцын ажлыг гүйцэтгэж, улсын

комисст хүлээлгэн өгсөн. Материалын захиалгыг цаг тухайд нь гүйцэтгэж, сайн ажилласан.

Хувьцаа эзэмшигчдийн санал шүүмжлэлийг сонссоны дараа компанийн 2021 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, 2021 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах, ТУЗ-ийн гишүүнээр Э.Тэмүүжинг сонгох санал хураалт явагдав.

Тооллогын комиссын дарга О.Шинэхүү санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Үүнд:


1. Компанийн 2021оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар.
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **126,701.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **126,701.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %
3. Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө, 2022 оны удирдлагын зардлыг батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **126,701.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд гүйцэтгэх удирдлага Энхжаргал овогтой Тэмүүжинг сонгох асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **126,701.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %

ХУРЛЫН ШИЙДВЭР:

Хурлын дарга Б.Мөнхбат: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
3. Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлав.
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд гүйцэтгэх удирдлага Энхжаргал овогтой Тэмүүжинг сонгов.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат үг хэлснээр 17.40 цагт хурал дуусав.

ПРОТОКОЛ ХЯНАСАН
ХУРЛЫН ДАРГА  Б.МӨНХБАТ

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Г.ГАНТУЯА